



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2019 оны 11 сарын 03 өдөр

Дугаар E/51

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
болон түүнийг дагалдан батлагдсан зарим
хуульд хориг тавих тухай

Монгол Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийг дагалдах хуулиудын хамт баталж, 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газарт ёсчлон ирүүлсэнтэй танилцлаа.

Улсын төсөв бол өнөө маргаашийн өчүүхэн эрх ашигт үндэслэх ёсгүй, хэтийн ололт, үр дагавар, эрсдэлийг тооцсон алсын хараатай нэгдмэл бодлого, эдийн засгийн тусгаар тогтнол, хараат бус, бие даасан байдлыг хангах нэгдсэн зорилтын хүрээнд батлагдах ёстой төрийн чухал бодлого мөн гэдгийг өнгөрсөн жилийн төсөв хэлэлцэгдэх үеэр Улсын Их Хуралд тусгайлан сануулж, улс орны эрх ашгийг дээдэлсэн, хэмнэлттэй, үр ашигтай төсөв батлах шаардлагыг удаа дараа тавьсан боловч үр дүнд хүрээгүй болно.

Түүнчлэн уул уурхайн бус экспортын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлэх, уламжлалт хөдөө аж ахуйдаа тулгуурлан мал аж ахуйн гаралтай баялаг, түүхий эдээ боловсруулж, экспортлох үйлдвэрүүдийг барьж байгуулах нь ажилгүйдэл, ядуурлыг эрс бууруулах, улс орны эдийн засагт үсрэнгүй хөгжил авч ирэх онцгой ач холбогдолтойг сануулж, тодорхой санал, санаачилга гаргасан боловч эрх баригчдаас улсын төсөвт тодорхой бодлого, арга хэмжээг тусган хэрэгжүүлэх эрмэлзэл, хичээл зүтгэл огт гарсангүй.

Монгол Улсын 2019 оны төсөв 1.9 их наяд төгрөгийн алдагдалтай, хэт үрэлгэн, татвар төлөгчдийн мөнгийг Улсын Их Хурлын гишүүдийн тойротг “авлига” мэтээр хуваарилсан, зураг төсөлгүй олон барилга, байгууламжийг барихаар тусгасан зэрэг алдаа дутагдал ихтэй, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг илэрхий зөрчсөн байдалтайгаар батлагдсан бөгөөд үр дүн нь Улсын Их Хурлын гишүүд тойротгоо хэдэн сургууль, цэцэрлэг барьснаа сайрхаж, сурталдахаас цааш хэтрээгүй гэж хэлж болно.

Энэ жил нөхцөл байдал өөрчлөгдсөнгүй, өмнөх жилийн алдаа, завхрал улам төгөлдөржиж, дахин давтагдсан байдалтай байна. Тухайлбал Улсын Их Хурлаар батлагдаад байгаа 2020 оны төсвийг сонгуулийн явцуу ашиг сонирхолд илт баригдсан, хэтэрхий өндөр зарлагатай, тухайн зарлагадаа тохируулж үндэслэл муутай, бүрдэхээргүй хийсвэр орлогыг ихээр төлөвлөж тооцсон, төсвийн алдагдлыг

0000000333

2.07 их наяд төгрөгт хүргэж улам нэмэгдүүлсэн зэрэг улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд хүндрэл учруулах олон дутагдалтай, алдаа ихтэй, эрсдэл бүхий төсөв болсон гэж дүгнэж болохоор байна.

Хэдийгээр улсын төсвийг батлах нь Улсын Их Хурлын бүрэн эрх мөн боловч хувь хүний ухамсар, ёс зүй болон албан тушаалтны хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд тодорхой хязгаарлалтууд тогтсон байдгийг гишүүн бүр анхаарвал зохино. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлд “засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж тус тус заасан байdag.

Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулиар Монгол Ардын нам “Иргэдээ ядуурлаас аварна” гэх уриатай сонгуулийн мөрийн хөтөлбөрийг ард иргэдэд танилцуулж, төсвийн алдагдал 1 их наяд төгрөг давах болсныг шүүмжлэн “үр ашиггүй зардлуудыг танаж хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна, татвар нэмэхгүй, шинээр татвар бий болгохгүй” гэсэн тодорхой амлалтуудыг ард түмэнд өгч, сонголт дэмжлэгийг нь татсанаар Үндсэн хуулийн дээрх үзэл санаа, зохицуулалтын дагуу төрийн эрх барих эрхийг олж авсан бол тухайн намаас нэр дэвшин сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд ТА бүхэн хувийн явцуу ашиг сонирхлоо хойш тавьж, нийт иргэн, улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах нэн хариуцлагатай үүргийг хүлээсэн болно.

Үндсэн хуульд тусгалаа олж, бусад хуулиар баталгаажсан ийм тодорхой болзоор ард түмний мэдэлд буй засгийн эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх эрх олж авсан намын, түүнээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр хий хоосон уриа, лоозон байж таарахгүй. Харамсалтай нь эрх баригчид ард түмэнд өгсөн дээрх болон “эдийн засгийн хямралын өртгийг иргэдээр төлүүлэхгүй” гэх мэт гоё сайхан амлалтуудаа бүрэн умартаж, татвар, төлбөр, шимтгэлийг нэмэгдүүлэх замаар ачааны хүндийг ард иргэдэд үүрүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал 2017 оноос хойш хадгаламжийн хүүгийн, хувь хүний орлогын, газар эзэмших, ашиглах эрх борлуулсны, импортын тамхины, согтууруулах ундааны, суудлын авто машины, шатахууны зэрэг 7 төрлийн татварыг нэмэгдүүлж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг нэмж, нийгмийн даатгалын шимтгэлийг 3 хувиар өсгөөд байгаа бол 2020 онд нийгмийн даатгалын шимтгэл дахин 2 хувиар өсөж, ард иргэдийн амьдралд учирч байгаа хүндрэл, дарамтыг улам нэмэгдүүлэн, бүрэн туйлдуулах нөхцөл бүрдээд байна.

Төсвийн үрэлгэн зардлуудыг танах, төрийн байгууллага, албан тушаалтнуудын тансаглалыг зогсоох, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд эргэлт, өөрчлөлт авч ирэх үр өгөөжтэй, хүртээмжтэй бодлого хэрэгжүүлэх ажил хэрэгч санал, шаардлагуудыг үл хэрэгсдэг атлаа татвар, төлбөр, шимтгэлийг нэмэгдүүлэх замаар нэг гараараа иргэдийнхээ халаасыг тэмтрэн, нэгөө гараараа тойргийнхоо иргэдийг хalamжилдаг эрх баригчдын энэ харалган, сонгуульд чиглэсэн явцуу бодлого улс орны амьдрал, хөгжилд гол түшиг болдог дундаж давхаргыг үгүйрүүлэх нэн таагүй үр дүнд хөтөлж, засаж залруулахад туйлын төвөгтэй, хүнд нөхцөл байдалд хүргэж байна.

Тиймээс Монгол Ардын нам, түүнээс нэр дэвшин сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдэд үүрэг хариуцлагаа ухамсарлах, ард түмэнд өгсөн амлалт болон авч хэрэгжүүлсэн бодлого, шийдлээ эргэн харах, алдаатай зарим бодлогоо энэ удаагийн

төсвөөр засаж, залруулах боломжийг олгох үүднээс Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль болон түүнийг дагалдан батлагдсан зарим хуульд хэсэгчилсэн байдлаар хориг тавих нь зүйтэй гэж үзлээ.

1. Монгол Улсын 2020 оны төсвийн хүрээнд нийгмийн даатгалын шимтгэлийн 2 хувийн нэмэгдлээс 174,2 тэрбум орчим төгрөг төвлөрүүлэхээр тусгасныг эрс эсэргүүцэж буй иргэдийн шаардлагыг Улсын Их Хурал хүлээн авч амлалт, хөтөлбөртөө нийцсэн хүнлэг, оновчтой бодлогоор нэн тэргүүнд залруулах шаардлагатай гэж үзэж байна.

2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй 46 мянга орчим ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын 19 мянга орчим нь 176,0 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй гэсэн тоон мэдээлэл байна. 2020 оноос нийгмийн даатгалын шимтгэл дахин нэмэгдэх тохиолдолд эдгээр ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын өр улам ёсөх, Нийгмийн даатгалын сангийн алдагдал ихсэх, ажил олгогчдын ажлын байр шинээр бий болгох болон ажилтныхаа цалин хөлсийг нэмэгдүүлэх сонирхол эрс буурах, дундаж давхаргын амьдрал дорийтох, ажилгүйдэл ядуурал улам тэлэх зэрэг ноцтой, сөрөг үр дагаврууд шууд бий болох эрсдэлтэй байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газар Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, ажил олгогчдын төлөөлөлтэй байгуулсан “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр”-ийн 5 дугаар зүйлд тусгагдсан “...нийгмийн даатгалын шимтгэлийг 2018 онд 2 хувь, 2019 онд 1 хувь, 2020 онд 2 хувь болгон нэмэгдүүлэх шийдвэрийг нийгмийн түншлэлийн талууд судалж, санал боловсруулан Улсын Их Хуралд хүргүүлнэ” гэсэн тохиролцлоо үл хайхран, зөрчсөн байдалтайгаар 2020 оны төсвийг боловсруулж, батлуулсныг хэлэлцээрийн талууд илт буруушаан, эсэргүүцэж байгааг мөн анхаарах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8 дахь хэсэгт “Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгох, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэн баталж болно” гэж заасан бөгөөд Улсын Их Хурал энэхүү хоригийг хүлээн авсан тохиолдолд дурдсан зохицуулалтын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлсэн холбогдох хуульд зохих өөрчлөлтийг оруулж, ард иргэдийн амьдралд дарамт болж байгаа буруу бодлогоо засах бүрэн боломжтой болно.

Мөн нийгмийн даатгалын шимтгэл нь иргэд, даатгуулагчдын ирээдүйд зориулсан хөрөнгө гэдгийг анхаарч, хариуцлагагүй байдлын уршгаар Капитал банканд өгч алдсан нийгмийн даатгал, эрүүл мэндийн сангийн 240 тэрбум төгрөгийг олж авах, татвар төлөгчдийн мөнгийг завшсан этгээдүүдээр нь буцаан төлүүлэх асуудалд Улсын Их Хурал “хуулийн биелэлтийг хянан шалгах” онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд анхаарал хандуулж, холбогдох байгууллагуудад үүрэг, чиглэл өгөн эрчимтэй, шуурхай ажиллуулах шаардлагатай гэж үзэж байна.

2. Монгол Улсын 2020 оны төсвийн нийт зарлага 13.87 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого 11.79 их наяд төгрөг болж, төсвийн алдагдал 2.07 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 5.1 хувьтай тэнцэхээр батлагдсан. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт

бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” тухай шаардлагад нийцээгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “Төсвийг ...батлах ...эрх бүхий байгууллага ...нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, мөн зүйлийн 6.2.1-ийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангах” гэснийг тус тус зөрчиж байна.

Ард иргэдийн амьдралд асар их дарамт, хүндрэл учруулж байгаа татвар, төсвийн бодлогоо анзаарч, хэт үрэлгэн зардлаа танаж засахын оронд урьд өмнө байгаагүй хэмжээний алдагдалтай төсвийг жил дараалан баталж, алдагдлыг улам нэмэгдүүлсээр байгаа нь улс орны эрх ашигт огт нийцэхгүй юм.

Монгол Ардын Нам 2016 оны сонгуулийн дараагаас өнөөг хүртэл төрийн эрхийг барихдаа төсвийн нийт алдагдлыг 9 гаруй их наяд төгрөгт хүргэж, 2016 онд хүлээж авсан 1.2 хувийн инфляцыг 9 хувьд хүргэн, ард иргэдийн амьжиригааг 8 пунктээр ядууруулсан хүнд нөхцөл бий болголоо. Өөрөөр хэлбэл эрх баригчдын хариуцлагагүй бодлого, үйл ажиллагаанаас үүдэлтэй инфляцын нэмэлт зардлыг халааснаасаа төлөх замаар төсвийн тэлэлт, төсвийн алдагдлын хор уршгийг зөвхөн иргэд нуруун дээрээ үүрч байна.

Түүнчлэн инфляцын түвшин 8-9 хувьд хүрэхийг гипер инфляц буюу хямралд тулсан босго үзүүлэлт гэж үздэг. Ийм эрсдэлтэй нөхцөлд эрх баригчид дүгнэлт хийж, инфляцыг бууруулах, иргэдийнхээ амьжиригааг дээшлүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ёстой. Харамсалтай нь улам алдагдалтай төсөв батлах замаар инфляцын одоогийн байгаа өндөр түвшинг ирэх 3 жилд ч буулгаж чадахааргүй, өөрсдийн явцуу эрх ашгийг өнөөдөр гүйцэлдүүлж байвал улс орны маргаашийн амьдрал, ирээдүй огт хамаагүй мэт бодлого явуулж байгааг хүлээн зөвшөөрөх аргагүй юм.

Тиймээс Улсын Их Хурал төсвийн зардлаа эргэн нягталж, үр ашиггүй, үрэлгэн зардлуудыг танах, үүний дотор 2020 оноос эхэлж, 2021-2022 оныг хүртэл хугацаанд дамжин хэрэгжих барилга, арга хэмжээний зардлуудыг төсвөөс бүрэн хасах шаардлагатай байна.

3. Монгол Улсын Их Хурал 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Ирээдүйн өв сангийн тухай хуулийг баталсан бөгөөд уг хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү хууль нь нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилго бүхий онцгой ач холбогдолтой, бодлого, зарчмынх нь дагуу цаг алдахгүйгээр хэрэгжүүлбэл зохих хууль мөн.

Гэтэл Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийг дагалдуулж Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд “Корпорац бие даасан тогтвортой үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болох хүртэл сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ, “Сангийн хөрөнгийн удирдлагыг энэ хуулийн дагуу байгууллагдах Корпорац хэрэгжүүлнэ” гэсэн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг Корпорац бие даасан тогтвортой үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болсноор дагаж мөрдөнө” гэсэн утга бүхий нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байх бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Ирээдүйн өв сангийн тухай хуулийг бүхэлд нь хэрэгжих бололцоогүй болгож, баялгаа зүй зохистой, тэнцвэртэй, ард иргэддээ

хүртээмжтэй ашиглах гэсэн Монгол төрийн нэг чухал бодлогыг тасалдуулахад хүргэж байна.

Тухайлбал Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан “Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, албан тушаалтнаас нөлөөлөхгүй, зааварчилгаа өгөхгүй байх, Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, энэ хуульд зааснаар шалгаруулах, томилох, гэрээ байгуулах ажиллагааг хэрэгжүүлэхэд бусдын нөлөөнд автахгүй, хараат бус, бие даасан байх” зэрэг зарчим болон эдгээрийн хүрээнд хэрэгжих ёстой хуулийн бусад зохицуулалтууд энэхүү нэмэлт, өөрчлөлтийн хуулиар мөн чанараа бүрэн алдаж, хэрэгжих ямар ч бололцоогүй болж байна.

Монгол Ардын нам төрийн эрхийг авч, улс орныг удирдсанаас хойш 4 дэх жилээ үзэх гэж байна. Энэ хугацаанд төсвийн болон бусад бодлогоо оновчтой, үр ашигтай болгох чиглэлд анхаарч, ард түмэнд өгөөжтэй, улс оронд хэрэгтэй ийм хуулийг амьдралд хэрэгжүүлэх бүрэн боломжтой байсан. Гэтэл хуулийг хэрэгжүүлэх бус хугацаагүйгээр зогсоох буюу гацаах бодлого оруулж ирж байгаа нь хүлээн зөвшөөрөх аргагүй болгож байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн:

1. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан, 2020 оноос эхэлж 2021, 2022 оныг дамжин хэрэгжих, хоригийн хавсралтад дурдсан, 1,424,277.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 386 барилга, арга хэмжээнд хэсэгчлэн,

2. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан 1,828,930.3 сая төгрөгөөс 2020 оноос эхэлж 2021, 2022 оныг дамжин хэрэгжих барилга, арга хэмжээнд төсөвлөсөн 350,846.7 сая төгрөгийг хасуулахаар тухай зүйлд хэсэгчлэн,

3. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийг дагалдаж батлагдсан Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлд нийгмийн даатгалын шимтгэлийн нэмэгдлээс төвлөрч, зарцуулагдах 174.2 тэрбум төгрөгийн хэмжээнд хэсэгчлэн,

4. Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийг дагалдаж батлагдсан Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд нь тус тус хориг тавьж байна.

Хоригийг зохих хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ үү.

Хавсралт ~~(21)~~ хуудастай.
(21)

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА



Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль болон түүнийг дагалдаж батлагдсан зарим хуульд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийн 1 дүгээр хавсралт

2020-2021 ОНД ХИЙГДЭХЭЭР ТУСГАГДСАН БАРИЛГА, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая.төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	"Алтай" чуулгын хуучин барилгыг "Багшийн хөгжлийн ордон" болгож өөрчлөх /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2020	2021	830.0	380.0
2	"Гандантэгчинлэн" хийдийн түүх соёл, шашны дурсгалт зүйлийг сэргээн тохижуулах /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2020	2021	1,000.0	400.0
3	"Монгол соёл-Монгол хүмүүн" төсөл хөтөлбөр /Говьсүмбэр/	2020	2021	3,500.0	1,200.0
4	"Монгол соёл-Монгол хүмүүн" төсөл хөтөлбөр /Дорнговь, Алтанширээ, Сайхандулаан, Өргөн, Даланжаргалан, Айраг, Дэлгэрэх, Иххэт, Мандах сум/	2020	2021	1,500.0	800.0
5	"Монголын нууц товчоо" түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилга /Хэнтий, Дэлгэрхаан сум/	2020	2021	1,500.0	1,000.0
6	"Шинэ хороо" төсөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7,8,9,10,11 дүгээр хороо/	2020	2021	8,000.0	4,500.0
7	"Шинэ хороо" төсөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23, 39 дүгээр хороо/	2020	2021	1,150.0	250.0
8	0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл /Үвс, Улаангом сум, 12 дугаар баг/	2020	2021	300.0	150.0
9	Аврах гал унтраах 10 дугаар ангийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2020	2021	13,424.0	3,235.0
10	Авто замын уулзварын гэрлэн дохио /Сүхбаатар, Баруун-Урт сум	2020	2021	800.0	400.0
11	Аймгийн төвийн авто замын их засвар, шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум, 4, 5, 8, 9, Өргөө баг/	2020	2021	1,900.0	300.0
12	Аймгийн төвийн хатуу хүчилттай авто замын шинэчлэл /Баян-Өлгийн, Өлгий сум/	2020	2021	4,487.4	1,487.4
13	Ахмадын өргөөний барилга /Булган, Булган сум/	2020	2021	1,300.0	800.0
14	Ахмадын өргөөний барилга /Орхон, Жаргалант сум/	2020	2021	800.0	300.0

15	Ахмадын өрөөний барилга / Хөвсгөл, Мөрөн сум, 10,11,12,13,14 дүгээр баг/	2020	2021	400.0	200.0
16	Ахмадын холбоо, сувиллын барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2020	2021	1,200.0	200.0
17	Ахмадын чийрэгжүүлэлтийн төвийн барилга худалдан авах /Хөвсгөл, Мөрөн сум/	2020	2021	250.0	100.0
18	Бага сургуулийн барилга, 240 суудал /Өвөрхангай, Сант сум/	2020	2021	1,500.0	400.0
19	Бага сургуулийн барилгын их засвар /Архангай, Өндөр-Улаан сум, Хануй баг/	2020	2021	300.0	150.0
20	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 23 дугаар хороо/	2020	2021	3,315.0	2,000.0
21	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо/	2020	2021	2,832.1	2,000.0
22	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо/	2020	2021	3,500.0	1,460.0
23	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 24 дүгээр хороо/	2020	2021	3,500.0	1,700.0
24	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7 дугаар хороо/	2020	2021	3,500.0	1,700.0
25	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор худалдан авах / Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо/	2020	2021	3,000.0	1,000.0
26	Багийн иргэний танхим /Дундговь, Өлзийт сум, 3 дугаар баг/	2020	2021	200.0	100.0
27	Багийн иргэний танхим /Дундговь, Өлзийт сум, 4 дүгээр баг/	2020	2021	200.0	100.0
28	Багийн сэргээгдэх эрчим хүчний холболт /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	2020	2021	263.0	150.0
29	Багийн төвийг эрчим хүчээр холбох /Хөвсгөл, Их-Уул сум, Мандал, Сараалж баг/	2020	2021	200.0	100.0
30	Багийн төвийн барилга /Ховд, Буянт сум, Цагаанбургас баг/	2020	2021	250.0	150.0
31	Багийн төвийн цогцолборын барилга /Орхон, Баян-Өндөр сум, Зээст баг/	2020	2021	2,050.0	700.0
32	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/	2020	2021	1,033.0	400.0
33	Багийн цогцолбор барилга /Орхон, Баян-Өндөр сум, Яргуйт баг/	2020	2021	2,050.0	850.0

	Багуудыг сумын төвтэй холбох цахилгаан дамжуулах агаарын шугам /Ховд, Булган сум/	2020	2021	200.0	100.0
34	Багшийн хөгжлийн хөтөлбөр /Дорнод/	2020	2021	2,000.0	1,000.0
35	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын нэгдсэн конторын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2020	2021	3,000.0	1,500.0
36	Баянбулаг хүүхдийн зусланг өндөр хүчдэлийн ЦДАШ-тай холбох /Ховд, Жаргалант сум/	2020	2021	890.0	200.0
37	Баянхошууны Баруун салааны авто замаас цэцэрлэг, сургуулийн цогцолбор хүртэлх авт зам, 1.0 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	2020	2021	1,400.0	600.0
38	Биеийн тамир хүүхдийн тоглоомын талбай /Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 10,11 дүгээр хороо/	2020	2021	400.0	240.0
39	Боловсрол, соёл, спортын салбарын их засвар /Өвөрхангай, Бат-Өлзий, Хархорин, Хужирт, Уянга, Зүүнбаян-Улаан сум	2020	2021	500.0	300.0
40	Бэлчээрийн гүний худаг /Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум/	2020	2021	300.0	120.0
41	Гаалийн боомтуудыг шилэн кабельд холбох /Улсын хэмжээнд/	2020	2021	5,500.0	3,000.0
42	Геронтологийн төвийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум/	2020	2021	500.0	150.0
43	Гудамжны тохижилт шинэчлэл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 14 дүгээр хороо/	2020	2021	550.0	200.0
44	Гэр хорооллын бохир усны шугам /Хөвсгөл, Мөрөн сум/	2020	2021	900.0	400.0
45	Гэр хорооллын гудамж зам талбайн гэрэлтүүлэг, камержуулалт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7,9,24,25,40,41,42 дугаар хороо/	2020	2021	1,000.0	500.0
46	Гэр хорооллын гудамж талбайн камержуулалт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 15 дугаар хороо/	2020	2021	300.0	150.0
47	Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2020	2021	610.0	400.0
48	Гэр хорооллын дундах авто зам, тохижолт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо/	2020	2021	400.0	100.0
49	Гэр хорооллын дундах зам засвар, тохижолт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо/	2020	2021	500.0	200.0

	Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжтай жишиг гудамж төсөл				
51	/Хөвсгөл, Мөрөн сум/	2020	2021	1,800.0	430.0
52	Дотуур байрын барилга /Дорнод, Хэрлэн сум, Хан-Уул цогцолбор сургууль/	2020	2021	1,783.0	500.0
53	Дотуур байрын барилга, 100 ор / Увс, ховд сум/	2020	2021	1,300.0	100.0
54	Дотуур байрын барилга, 100 ор /Дорнод, Хөлөнбуйр сум/	2020	2021	1,607.1	400.0
55	Дотуур байрын барилга, 150 ор /Баянхонгор, Богд сум/	2020	2021	2,100.0	500.0
56	Дотуур байрын барилга, 50 ор /Төв, Баянхангай сум/	2020	2021	942.0	300.0
57	Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2020	2021	1,000.0	300.0
58	Дотуур байрын барилга, 75 ор /Завхан, Асгат сум/	2020	2021	1,000.0	300.0
59	Дотуур байрын өргөтгөлийн барилга /Архангай, Хангай сум/	2020	2021	300.0	150.0
60	Дулааны станцын 2 дугаар хэлхээний шугам сүлжээний үргэлжлэл /хэntий, Хэрлэн сум/	2020	2021	1,000.0	500.0
61	Дунд голын гүүр /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо/	2020	2021	1,800.0	100.0
62	Дүүргийн соёлын төв дагуух хатуу хүчилттэй авто зам, 1.6 км /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	2020	2021	1,800.0	600.0
63	Дэлүүн болдог нисэх буудлын барилга /Хэнтий, Дандал сум	2020	2021	5,000.0	2,000.0
64	Ерөнхий боловсролын сургуулийн компьютерийн лабораторийн шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 19, 20, 38, 51, 73, 141 дүгээр сургууль/	2020	2021	200.0	130.0
65	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Баатагаан сум/	2020	2021	1,200.0	372.2
66	Засаг даргын Тамгын газрын барилга /Булган, Баян-Агт сум/	2020	2021	806.3	200.0
67	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан аймаг, Түдэвтэй сум/	2020	2021	1,200.0	400.0
68	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан аймаг, Ургамал сум/	2020	2021	1,200.0	400.0
69	Засаг даргын Тамгын газрын барилга /Завхан аймаг, Шилүүстэй сум/	2020	2021	1,200.0	400.0
70	Засаг даргын Тамгын газрын барилга /Өвөрхангай аймаг, Хайрхандулаан сум/	2020	2021	800.0	300.0
71	Засаг даргын Тамгын газрын барилга /Ховд, Чандмань сум/	2020	2021	1,200.0	300.0
72	Засаг даргын тамгын газрын барилга /Хөвсгөл, Түнэл сум/	2020	2021	1,200.0	350.0
73	Засаг даргын тамгын газрын барилга /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2020	2021	1,200.0	350.0

74	Зэөврийн усан сан /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2020	2021	600.0	300.0
75	Зуунмод-Манзушир чиглэлийн хатуу хүчилттай авто зам, 7.0 км /Төв, Зуунмод сум/	2020	2021	6,576.9	3,500.0
76	Инженерийн дулааны шугам сүлжээ /Хэнтий, Баянмөнх сум/	2020	2021	781.7	250.0
77	Инженерийн хийцтэй гүний худаг /Сүхбаатар/	2020	2021	1,000.0	450.0
78	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл /Ховд, Зэрэг сум/	2020	2021	800.0	400.0
79	Их Монгол Улс, Монголын Эзэнт гүрэн цогцолборын барилгын интерьєр, дотоод уран сийлбэр шинэчлэл, гадна цахилгаан хангамж /Хэнтий, Биндэр сум/	2020	2021	2,600.0	1,100.0
80	Мал угаалгын суурин ванн /Сүхбаатар/	2020	2021	600.0	300.0
81	Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пункт /Сүхбаатар/	2020	2021	1,000.0	450.0
82	Мал эмнэлгийн эмийн сорил баталгаажуулалтын улсын лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2020	2021	1,632.7	816.4
83	Модон гүүр /Увс, Завхан сум, Хармагт баг/	2020	2021	300.0	120.0
84	Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон	2020	2021	5,000.0	3,272.9
85	Монголын их хаадын шүтээн цогцолбор судлалын төвийн барилга /Төв, Аргалант сум/	2020	2021	2,504.2	500.0
86	Мөнгөнхараа чуулгын байрын их засвар, тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Мандал сум	2020	2021	1,200.0	700.0
87	Музейн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2020	2021	5,000.0	500.0
88	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 15,16,17,18,19,20 дугаар хороо/	2020	2021	2,000.0	500.0
89	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн болон kontорын барилга /Дорнод, Чойбалсан сум/	2020	2021	2,580.7	500.0
90	Наадмын талбайн тохижилт /Увс, Улаангом сум/	2020	2021	1,000.0	500.0
91	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2020	2021	2,000.0	500.0
92	Нийтийн орон сууцын гадна фасад /Хэнтий, Бор-Өндөр сум/	2020	2021	550.0	200.0
93	Нийтийн эзэмшлийн байруудын гэрэлтүүлэг /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2020	2021	80.0	40.0

94	Нийтийн эзэмшлийн байруудын инженерийн шугам сүлжээний засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон баг, 1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12,13 дугаар баг/	2020	2021	430.0	80.0
95	Нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний засвар, өргөтгөл, шинэчлэл /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 8, 10, 12, 13, 14, 22 дугаар хороо/	2020	2021	700.0	233.0
96	Нийтийн эзэмшлийн о/с-ны дээврийн засвар/ Увс, улаангом, 3 баг/	2020	2021	830.0	300.0
97	Нийтийн эзэмшлийн орон сууц, гэр хорооллын гудамж зам талбайн гэрэлтүүлэг /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2020	2021	140.0	140.0
98	Нийтийн эзэмшлийн орон сууцын байруудын гадна фасад, дулаалгын засвар / Увс, Улаангом сум, 3 дугаар баг/	2020	2021	1,330.0	400.0
99	Нийтийн эзэмшлийн орон сууцын гадна талбайн тохижилт /Улаанбаатар, Багануур дүүрэг, 1 дүгээр хороо/	2020	2021	650.0	300.0
100	Нийтийн эзэмшлийн орон сууцын дээврийн засвар /Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 12, 13, 14, 15, 16, 17 дугаар хороо/	2020	2021	1,023.0	600.0
101	Нийтийн эзэмшлийн орон сууцын их засвар / Дархан-Уул, Дархан сум, 4,5,8,9, Өргөө баг/	2020	2021	800.0	500.0
102	Нийтийн эзэмшлийн орон сууцын их засвар / Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 12,13,14,15,16,17 дугаар хороо/	2020	2021	1,007.0	700.0
103	Нийтийн эзэмшлийн орон сууцын орцын их засвар / Улаанбаатар, Багануур дүүрэг 1 дүгээр хороо/	2020	2021	150.0	100.0
104	Нийтийн эзэмшлийн орон сууцын орцын их засвар / Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 18,19,27,29,38 дугаар хороо/	2020	2021	800.0	300.0
105	Нийтийн эзэмшлийн орон сууцын орцын их засвар / Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 7,8,9,10 дугаар хороо/	2020	2021	900.0	600.0
106	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13,14,15,16,17,18,19,20 дугаар хороо/	2020	2021	1,640.0	640.0
107	Нисэхийн эцсийн автобусны өүүдлаас Сонсголонгийн төв зөм хүртэлх хатуу хүчилттэй авто зам /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо/	2020	2021	3,200.0	1,000.0

108	Номын төвийн өргөтгөл /Орхон, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг/	2020	2021	546.4	250.0
109	Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Архангай, Эрдэнэбулаг/	2020	2021	17,000.0	500.0
110	Онги голын төмөр бетон гүүр, 54.8 у/м /Дундговь, Сайхан-Овоо сум/	2020	2021	1,528.4	500.0
111	Онон голын төмөр бетон гүүр, 209.0 у/м /Хэнтий, Биндэр сум/	2020	2021	6,400.0	1,000.0
112	Орон сууцын байруудын фасадын дулаалга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 1,2,3,12 дугаар хороо/	2020	2021	1,700.0	1,000.0
113	Орон сууцын гадна тохижилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7,8,9,10 дугаар хороо/	2020	2021	2,000.0	500.0
114	Орон сууцын гадна фасадын засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7,8,10 дугаар хороо/	2020	2021	1,000.0	500.0
115	Орон сууцын дулааны шугам сүлжээ, 60 айл /Сэлэнгэ, Сүхбаатар сум, Орхон, 6 дугаар баг/	2020	2021	150.0	150.0
116	Орон сууцын хороолол доторх гэрэлтүүлэг шинэчлэл /Дархан-Уул, Дархан сум, 4, 5, 8, 9 Өргөө баг/	2020	2021	800.0	300.0
117	Орхон голын төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Орхонтуул сум/	2020	2021	5,500.0	1,000.0
118	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан 4,5,6,7,8,9 өргөө	2020	2021	400.0	50.0
119	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улаанбаатар, Багануур дүүрэг, 3 дугаар хороо/	2020	2021	250.0	80.0
120	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо/	2020	2021	200.0	80.0
121	Прокурорын газрын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум	2020	2021	1,597.2	798.6
122	Прокурорын газрын барилга /Дорнод, Хэрлэн сум/	2020	2021	1,652.6	826.3
123	Прокурорын газрын барилга /Завхан, Улиастай сум/	2020	2021	1,837.0	918.5
124	Прокурорын газрын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2020	2021	4,538.6	1,269.3
125	Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын 2 дугаар шатны тохижилт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 19 дүгээр хороо, дээд Салхит/	2020	2021	2,100.0	500.0

	Соёл, спорт, аялал жуулчлалын цогцолборын хувцас солих байр, тусlamж үйлчилгээ, нийтийн соёл үйлчилгээний барилга, байгууламж, өвлийн спортын талбай /Улаанбаатар, Чингэлтэй, 19 дүгээр хороо, Дээд Салхит/	2020	2021	2,900.0	1,500.0
126	Соёл, спортын төвийн барилга /Төв, Баянжаргалан сум/	2020	2021	1,200.0	500.0
127	Соёл, спортын төвийн барилга /Төв, Борнуур сум/	2020	2021	2,000.0	360.0
128	Соёл, спортын төвийн барилга /Төв, Сэргэлэн сум/	2020	2021	1,200.0	500.0
129	Соёлын ордны гадна тохижолт /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/	2020	2021	2,000.0	1,000.0
130	Соёлын төв, спорт заалын их засвар /Архангай, Хангай сум/	2020	2021	300.0	100.0
131	Соёлын төвийн барилга /Архангай, Булган сум/	2020	2021	1,150.0	250.0
132	Соёлын төвийн барилга /Архангай, Жаргалант сум/	2020	2021	1,150.0	200.0
133	Соёлын төвийн барилга /Архангай, Чулуут сум/	2020	2021	1,150.0	300.0
134	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Баянлиг сум/	2020	2021	1,750.0	1,000.0
135	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Өлзийт сум/	2020	2021	1,300.0	800.0
136	Соёлын төвийн барилга /Дундговь, Дэлгэрцогт сум/	2020	2021	1,000.0	500.0
137	Соёлын төвийн барилга /Төв, Баянчандмань сум/	2020	2021	1,500.0	400.0
